



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХСАН ЗААЛТ
БУЙ ЭСЭХЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, БУСАД ОРНЫ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ТАЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХСАН ЗААЛТ БУЙ ЭСЭХЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, БУСАД ОРНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА¹

УДИРТГАЛ

Энэхүү судалгааг Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор гүйцэтгэв. Судалгааны Нэгдүгээр бүлэгт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, ялгаварлан гадуурхах үзэгдлийн ойлголт, Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, ялгаварлан гадуурхахаас сэргийлэх эрх зүйн орчны талаар авч үзсэн.

Судалгааны Хоёрдугаар бүлэгт, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж буй асуудлыг хөндсөн бөгөөд олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах үзэгдэл, бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид ХБХЭ-ийн тулгамдаж буй асуудлыг Монгол Улсад хэрхэн шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар судлахыг зорилго.

Судалгааны Гуравдугаар бүлэгт, Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах зохицуулалт хэрхэн хэрэгжиж буйг дүгнэх зорилгоор судалгааны Нэгдүгээр бүлэгт тодорхойлсон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг хууль зүй, боловсрол, хөдөлмөр, дэд бүтэц, нийгмийн даатгал, халамж, хамгаалал, бусад салбарын хүрээнд судалсан.

Энэхүү судалгаагаар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг дүгнэхийн зэрэгцээ цаашид боловсронгуй болгох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг заавал дагаж мөрдөх олон улсын гэрээ болгож баталгаажуулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэмдээ хүндтэй байр суурь эзэлж, биеэ даан амьдрах боломжийг баталгаажуулахыг зорьсон. Уг конвенцид Монгол Улс 2008 онд нэгдэн орсноор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг дээшлүүлэн 2016 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийг шинэчлэн баталсан.²

Энэхүү хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 2017 оны 116 дугаар тогтоолд Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус зөвлөл байгуулах тухай заасны дагуу 2018 онд ХЗДХЯ-ны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд “Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй /цаашид ХБ гэх/ хүнийг ялгаварлан гадуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх, бусад орны хууль тогтоомжийн талаар харьцуулсан судалгаа” хийх тухай заасан юм.

¹ Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга гүйцэтгэв.

² Лорд Дюпонт. Хүний эрхийн төлөө: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл. Нээлттэй нийгэм форум. “Хүний эрхийн боловсрол” цуврал №6, УБ., 2009. /Х тал/.

ХЗДХЯ-аас ирүүлсэн төлөвлөгөөт ажлын дагуу Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх хэсэг “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан”, 3.2.5 дахь хэсэг “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол” гэсэн нөхцөлийг хангаж байгаа хэмээн дүгнэх боломжтой тул энэхүү үнэлгээг гүйцэтгэв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Судалгааны хүрээг захиалагчаас ирүүлсэн саналын дагуу Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоос ХБХ ялгаварлан гадуурхалтад хамгийн ихээр өртөж байгаа салбараас сонгож дараах байдлаар үнэлгээний хүрээг тогтоов.

- Хууль зүйн салбарын хүрээнд.
- Боловсролын салбарын хүрээнд.
- Хөдөлмөрийн салбарын хүрээнд.
- Нийгмийн даатгал, халамж хамгааллын салбарын хүрээнд.
- Дэд бүтцийн салбарын хүрээнд.
- Бусад салбарын хүрээнд.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний ажлын хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход дараах шалгуур үзүүлэлтээс тохиромжтойг тогтооно.

- зорилгод хүрсэн түвшин;
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- практикт нийцэж байгаа байдал;
- бусад үр дагавар

ХБХЭ-ийг зөрчсөн хуулийн заалтад тохируулан оновчтой, бодитой, хэмжиж болохуйц тодорхой нэг шалгуур үзүүлэлтийг сонгон авч үнэлэх юм.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрээс сонгоно.

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх тухай харьцуулалтын хэлбэрийг ашиглав. ХБХ-ийг ялгаварлан гадуурхахын эсрэг бусад улсын хууль тогтоомжид тусгасан боловсрол эзэмших эрх, хөдөлмөрлөх эрхийн

хэрэгжилтийн талаар харьцуулах, мөн судалгаанд дурдсан тоо баримт, дэвшүүлсэн санал зэргийг батлах үүднээс тохиолдол судлах аргыг ашиглах нь тохиромжтой байна.

1.5. Мэдээлэл цуглуулах арга

Судалгаанд холбогдох хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлав.

Судалгаанд хараат бус, бие даасан байдлаар гүйцэтгэх шинжлэх ухааны арга зүйг баримтлан, баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, ярилцлагын аргыг ашигласан бөгөөд судалгааны дүгнэлт, зөвлөмжийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоосон үр дүнд үндэслэсэн болно. Төрийн байгууллага, Төрийн бус байгууллага, судлаачид, зэрэг 10 орчим оролцогчоос бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага авч, баримтжуулан тэдний зөвшөөрөлтэйгөөр авч ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1. Монгол Улс дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалт: хөгжлийн бэрхшээлтэй хүнд холбогдох эрх зүйн зохицуулалт

2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн тухай

Хүний эрхийг дээдлэх нь ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь юм. Хүний эрхийн гол зарчим бол хүний бие, сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл, боломж бий болгоход оршино.

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрхийг дээдлэн, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг тунхагласан тухай доктор, профессор Б.Чимид тайлбарлахдаа “Хүнийг дээдэлж, түүний эрх, эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм.”³ Хүний эрх, эрх чөлөөг зөвхөн Үндсэн хуульд тодорхойлсон томъёоллоор хязгаарлан ойлгож, судалж, үнэлж, хамгаалж болохгүй. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд авч үзвэл зохино”⁴ гэж үзсэн. Харин Монгол Улсын Үндсэн хуульд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан байдаг.

ХБХЭТ хуулиар “хүн бүр ХБ эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг ХБ болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.” хэмээн Монгол Улсын Үндсэн хуулиар заагдсан хүний эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан нь ХБХ эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх утгыг бүрэн дүүрэн илэрхийлж өгсөн байна.

Манай улс ХБХ ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн тухай баталгаажуулсан олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орж хүлээн зөвшөөрсөн байдаг. Тухайлбал:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол,
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

³ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017 он. 56 дахь тал.

⁴ Мөн тэнд. 194 дэх тал

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол,
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, ажил эрхлэлтийн тухай 168 дугаар зөвлөмж,
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенци,
- Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай,
- Нүд сохлогч лазерийн зэвсгийн тухай протокол,
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 122 дугаар зөвлөмж,
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенци,
- Хүүхдийн эрхийн тухай конвенци, гэх мэт 30 шахам Олон улсын гэрээг дагаж мөрддөг.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци” болон бусад нэгдэн орсон Олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулиар заасан эрх, эрх чөлөөг ХБХ бусад иргэний нэгэн адил эдлэх эрхтэй төдийгүй ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй.

2.1.2. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж.

Монгол Улсын хэмжээнд төр, хувь хүн, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд хоорондын харилцааг зохицуулан үйлчилж буй хүчин төгөлдөр нийт 9278⁵ эрх зүйн акт байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй дараах хууль тогтоомж байна.

- Олон улсын гэрээ 29
- Хууль 76
- Улсын Их Хурлын тогтоол 13
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 3
- Улсын дээд шүүхийн тогтоол 21
- Засгийн газрын тогтоол 28 байна. (хавсралт)

Дээрх хууль тогтоомжоос ХБХ-ийг ялгаварлан гадуурхсан зохицуулалтад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээг хийх явцад “Тахир дутуу” гэсэн нэр томъёотой зохицуулалтаар 42 хууль тогтоомж, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийг ишлэсэн, Боловсролын тухай хуульд эшлэл буруу авсан зэрэг зөрчил илэрч байна. /Дэлгэрэнгүйг 3-р бүлгээс танилцана уу./

2.2. Гадаадын зарим орны туршлага

Дэлхийн банк болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага дэлхийн хүн амын 15 хувь нь ХБХ байдаг бөгөөд нэг тэрбум хүн буюу 80 хувь нь буурай хөгжилтэй улс орнуудад амьдарч, тэдгээрийн ихэнх нь халдварт саа өвчин туссан, эсвэл дүлий, хараагүй, оюуны ХБ, чихрийн шижин өвчин, сэтгэл гутрал, гэмтлийн дараах сэтгэцийн хямрал, ХДХВ, ДОХ зэрэг бодит ба далд хэлбэрийн ХБ хүмүүс байна. Хүний эрхийн зөрчлийг бүрэн дүүрэн тусгасан Конгрессийн бүрэн эрхийн хүрээнд боловсруулдаг улс орнуудаас Хүний эрхийн тайланг үргэлжлүүлэн сайжруулж дэлхийн 160 гаруй улс орон ХБХ эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг соёрхон баталсан⁶.

⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх эрх зүйн акт.
<http://legalinfo.mn/> сүүлд үзсэн 2018.6.13.

⁶ Хатартай Трүдо 2016 онд хэлсэн үг. <https://mn.usembassy.gov/mn/remarks-honor-26th-anniversary-americans-disabilities-act-mn/> сүүлд үзсэн 2018.6.7.

Манай улсад ердийн өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчний шинж байдлаар ХБ-ийг тодорхойлж 2017 оны байдлаар 103.630 ХБХ байна гэсэн тоо баримтыг Үндэсний статистикийн хорооноос⁷ гаргасан байна. ХБХ нийгэмд бодит хувь нэмэр оруулж чаддаг гэдгийг хууль тогтоомжуудаар дамжуулан иргэдэд хүргэж байх нь зүйтэй бөгөөд тэдний боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах, хөдөлмөрлөж нийгэмд эзлэх байр сууриа тодорхойлох нь тэднийг бусдын адил тэгш эрхийг хүртэх бололцоог бий болгох юм. Энэ тухай дэлгэрүүлэн НҮБ Хүний эрхийн тайланг үргэлжлүүлэн сайжруулсан томоохон улсуудаас төлөөлүүлэн АНУ, ОХУ, ХБНГУ-ын тухай авч үзэв.

2.2.1. Америкийн Нэгдсэн Улс

1990 онд Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хууль⁸ батлагдсан нь АНУ-ын 52 сая гаруй ХБ иргэдийн хувьд Эрх чөлөөний тунхаг⁹ болсон юм. Тус хуульд ялгаварлан гадуурхахыг хориглодог, нийгмийн харилцаанд ХБ хүмүүс бусад хүмүүстэй адил тэгш оролцох боломж олгодог. Өөрөөр хэлбэл хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, орон сууц, нийтийн байр, боловсрол, тээвэр, харилцаа холбоо, амралт, институцийн зохион байгуулалт, эрүүл мэндийн үйлчилгээ, нийтийн үйлчилгээнд хамрагдах, санал өгөх зэргээр Америкийн өдөр тутмын амьдралд хамгийн өргөн хүрээтэй оролцох эрхээр хангагдсан хууль юм.

Нөгөө талаар ХБ хүнийг хүн амын тооллогын мэдээлэл, үндэсний санал асуулга болон бусад судалгаагаар нийгмийн доод бүлэгт хамруулан үзэж нийгэм, эдийн засаг, боловсролын түвшинд шударга бус, шаардлагагүй ялгаварлан гадуурхах явдлыг тасралтгүй үргэлжлүүлэн оршин тогтнох нь ХБ хүмүүс тэгш эрхтэйгээр өрсөлдөх боломжийг хязгаарлан, АНУ-ын тэрбум тэрбум долларыг шаардлагагүй зардал болгож байгааг үр ашигтай зарцуулах тухай буюу ХБХ нийгмийн харилцаанд оролцоход тулгамдсан асуудлыг зохицуулахад чиглэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хуулиар хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төдийгүй хуулийн 1-р зүйлээс эхлэн хөдөлмөр эрхлэлтийн тухай заасан. Ажилтан, ажил олгогч, хөдөлмөрийн холбоод, нөхөрлөл, корпораци, хууль ёсны төлөөлөгч, хувьцаат компаниуд, итгэмжлэгдсэн байгууллагууд, итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулсан. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой харилцааг энэ хуулиас гадна 1964 оны Иргэний эрхийн тухай хууль¹⁰, Нөхөн сэргээлтийн тухай хууль¹¹, бусад хууль тогтоомжоор зохицуулсан байна. Ажил олгогч нь ажлын долоо хоногт 20 буюу түүнээс дээш цагтай, 15 буюу түүнээс дээш ажилтантай бизнес эрхэлдэг хүн байх тухай заасан бол ХБ мэргэшсэн ажилтан нь ярилцлага хийх ба ажил үүрэгтэй холбоотойгоор бичгээр тайлбар хийж болно. Ажил олгогчийн зүгээс энэ тодорхойлолтыг ажил үүргийн нэн чухал нотолгоо гэж үзэн үнэлэх, мөн ажилд авах өргөдөл гаргах журам, ажилд авах, дэвшүүлэх, ажлаас чөлөөлөх зэрэгт ялгаварлан гадуурхаж үл болох тухай заасан.

АНУ-ын хувьд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, байр сууцаар хангах, хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад анхаардаг бол, Аж ахуйн нэгж нь ажил үүрэг гүйцэтгэх чадварт нь лавлагаа хийх, эрүүл мэндийн үзлэг шалгалтад

⁷ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүйс, аймаг, нийслэлээр. http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_3300_014V1 сүүлд үзсэн 2018.6.10.

⁸ The Americans with Disabilities Act (ADA) was signed into law on July 26, 1990 https://www.ada.gov/ada_intro.htm

⁹ Хатагтай Трудо 2016 онд хэлсэн үг. <https://mn.usembassy.gov/mn/remarks-honor-26th-anniversary-americans-disabilities-act-mn/> сүүлд үзсэн 2018.6.7.

¹⁰ Title VII of the Civil Rights Act of 1964: Equal Employment Opportunity <https://employment.findlaw.com/employment-discrimination/title-vii-of-the-civil-rights-act-of-1964-equal-employment.html>

¹¹ The Rehabilitation Act of 1973 <https://www2.ed.gov/policy/speced/reg/narrative.html>

хамрагдахыг ажилд орох бүх ажилтан тахир дутууг үл харгалзан шаардаж болох бөгөөд өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн байдал, түүхийн талаар олж авсан нууц мэдээллийг тусдаа маягт болгон хадгалах өөрөөр хэлбэл хувь хүний нууцлалд эрх, тэгш хандах эрхийг хүндэтгэх мөн дэмжлэг шаардагдсан хувь хүн байвал төлөөллийг оролцуулах зэргээр ХБ иргэдэд хөдөлмөр эрхлэх боломж, хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч байхад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх ажлыг АНУ-ын Хөдөлмөрийн яамны дэргэдэх ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн алба (The Office of Disability Employment Policy (ODEP))¹² олон нийтийн оролцоонд түшиглэн гүйцэтгэдэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хууль батлагдсанаас хойш ажилдаа автобус, галт тэргээр чөлөөтэй зорчдог төдийгүй 70-аад оны эхэнд ХБ-ийн улмаас ажилд авахгүй гэдэг байсан нь өнөөгийн байдлаар ялгаварлан гадуурхалтад тооцогдох болсон.

Боловсрол эзэмших эрх

АНУ-ын Дээд шүүхээс ялгаварлан гадуурхалт байх ёсгүй бөгөөд боловсролыг бүх иргэдэд адил тэгш хэлбэрээр олгож байх нь Засгийн газрын үндсэн үүрэг гэж үзсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын тухай хуулиар¹³ тэдний өвөрмөц хэрэгцээг хангах, цаашид боловсрол эзэмшихэд нь бэлтгэх олон нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгох эрхээ эдлэх боломжийг олгодог. Мөн энэ хууль нь “А”, “Б”, “С”, “Д” гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэх бөгөөд “А” хэсэг нь үндсэн хэсгийг зохицуулах бөгөөд “Б” хэсэгт 3-21 насны хүүхдүүдэд зориулсан боловсролын туслалцаа үзүүлэх тухай удирдамжийг боловсруулсан, “С” хэсэгт 3 хүртэлх насны хүүхдийн хөгжилд анхаарч, хүүхдийн хөгжлийг төрөөс дэмжих, санхүүжүүлэх тухай зохицуулсан, “Д” хэсэгт ХБ хүүхдийн боловсролыг сайжруулахад чиглэсэн үндэсний үйл ажиллагааг дэмжсэн, ХБ оюутанд олгодог буцалтгүй тусламжийг сайжруулах, ХБ хүүхдэд эерэг үр дүн үзүүлж байгаа төсөл хөтөлбөрийг дэмжихэд чиглэсэн.

Үүнээс гадна Нөхөн сэргээлтийн тухай хуулиар ХБ залуучууд, оюутнуудыг хамгийн боломжтой дээд түвшинд бэлтгэх бололцоогоор хангадаг байна. Сенатын зөвлөгөө, зөвшөөрөлтэйгөөр Боловсролын яаманд Нөхөн сэргээлтийн үйлчилгээний газар хэмээх агентлаг байх бөгөөд Комиссар ахална. Комиссар нь Департаментийн гол ажилтан байна. Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хуулийн 309 дэх хэсэгт ХБИ зориулсан шалгалт болон курсийн тухай тусгаж өгсөн. Мөн Иргэний эрхийн тухай хуулиар зохицуулагдсан байна.

2.2.2. Оросын Холбооны Улс

ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль”¹⁴ 1995 онд батлагдсан. Энэхүү хуулиар ОХУ-д ХБИ-ийн нийгмийн хамгааллын салбарт төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, ОХУ-ын Үндсэн хуульд заасан иргэний, эдийн засаг, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд ХБХ-ийг адил тэгш боломжоор хангах зорилготой юм.

Хөдөлмөр эрхлэлт

ОХУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль болон ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хуулиар¹⁵ ХБИ-ийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхөд аюулгүй байдлын баталгаа гаргаж өгдөг төдийгүй мэргэжлээрээ

¹² The Office of Disability Employment Policy (ODEP) under the US Department <https://www.nypl.org/blog/2015/06/24/employment-services-disabilities>

¹³ The individuals with Disabilities Education Act (IDEA) <http://www.apa.org/advocacy/education/idea/index.aspx>

¹⁴ «О социальной защите инвалидов в Российской Федерации». <http://docs.cntd.ru/document/901713539> со ст. 20-24

¹⁵ “Трудовой кодекс”. <http://docs.cntd.ru/document/901807664/> со ст. 92-261

ажиллах, шинэ мэргэжил эзэмших, сургалт зохион байгуулах, ажлын байрны нөөцийг нэмэгдүүлэх, ажиллах нөхцөл бололцоогоор хангах буюу нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан тусгай ажлын байрыг бий болгох явдлыг дэмжсэн бөгөөд 100-гаас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн 2 хувиас доошгүй 4 хувиас дээшгүй байхаар квот тогтоож өгсөн байна. Хөдөлмөрийн тухай хуулиараа 1-2 дугаар группийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цаг долоо хоногт 35 цагаас илүүгүй, ээлжийн амралтыг хуанлийн 30 хоногоос доошгүй, харин цалингүй амралтыг 60 хоног хүртэл олгох бөгөөд өөрийнх нь бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр амралтын өдөр, шөнийн цагаар ажиллуулахад татгалзах эрхтэй байх тухай заасан байна.

Боловсрол эзэмших эрх

ОХУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль болон Боловсролын тухай хуулиар¹⁶ зохицуулах бөгөөд ХБИ боловсрол, сургалт явуулахад шаардлагатай нөхцөлүүдийг төрөөс баталгаажуулдаг. ХБИ боловсрол эзэмших явдлыг бүхий л талаар дэмжин, үүний тулд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангах, төрийн үүрэг хариуцлагыг баталгаажуулах үүднээс боловсролын салбарт ХБИ өөрсдийн боловсрол эзэмших нөхцөлийг хөгжүүлэх, ХБ-ийг засах, нийгэмд дасан зохицоход чиглэсэн тусгай сурган хүмүүжүүлэх арга барилыг нэмэгдүүлсэн. Мөн бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг баталгаажуулсан нь бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг эдлэх, тэдгээрийн бие хүний болон хувийн онцлог, боломжийг хөгжүүлэх, нийгмийн хөгжилд татан оролцуулахад чиглэгддэг.

Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ХБ хүүхэд залуучууд, тэдгээрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчдийг мэдээллээр хангах, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, дэмжлэг үзүүлэн, ХБ хүүхдийг гэрийн нөхцөлд нь сургахад дэмжлэг үзүүлэх, гэрээр боловсрол олгоход нь гаргах зардлын хэмжээг эрх зүйн актад тусгасны дагуу эцэг, эхэд олгодог мөн мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй ба 1-2 дугаар группийн ХБИ-д техникийн дээд сургууль, техникийн дунд боловсролын сургуульд элсэлтийн уралдаант шалгалтгүйгээр элсэн орох эрхтэй бөгөөд тэдэнд оюутны цалинг 50 хувиар нэмэгдүүлэн олгодог байна.

2.2.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль¹⁷ (Behindertengleichstellungsgesetz-BGG) 2002 онд батлагдсан. Хуулийн зорилго нь ХБ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, тэдний нийгмийн амьдралд тэгш оролцох, өөрсдийгөө тодорхойлдог амьдралын хэв маягийг бий болгоход нь туслахын зэрэгцээ тэдний онцгой хэрэгцээг төрөөс харгалзан үзэх явдал юм.

Хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай хууль¹⁸ (Schwerbehindertengesetz-Schwbg) нь 1953-2001 онуудад ХБИ-ийн асуудлыг зохицуулсан. 2001 онд дээрх хуулийг Нийгмийн хуулийн IX (Sozialgesetzbuch SGB IX) дэх хэсэгт нэгтгэн мөрдөж эхэлсэн. Үүнд ХБИ-ийн нөхөн сэргээлт, оролцооны зохицуулалтыг оруулсан. Хүнд хэлбэрийн ХБ хүмүүс тэдгээртэй ижил хүмүүс Хөдөлмөрийн тухай хуульд тусгай хамгаалалт эдэлнэ¹⁹. Түүнчлэн 50 хувиас доош

¹⁶ Об Образований <http://www.consultant.ru/search/base/?q=об+образования> со ст. 36-95,

¹⁷ Gesetz zur Gleichstellung von Menschen mit Behinderungen (Behindertengleichstellungsgesetz - BGG) <https://www.gesetze-im-internet.de/bgg/BJNR146800002.html>

¹⁸ Schwerbehindertengesetz (Schwbg), Gesetz zur Sicherung der Eingliederung Schwerbehinderter in Arbeit, Beruf und Gesellschaft <https://behinderung.org/gesetze/schwbg.htm>

¹⁹ Beschäftigung von Schwerbehinderten Menschen. Stand: Januar 2017. <https://www.ihk-kassel.de/solva>

түвшний ХБИ зохих газруудад хандан хүнд хэлбэрийн ХБИ-тэй нэгэн адил эрх эдлэн дээрх хуулийн заалтын дагуу хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах боломжтой.

ХБ-ийг тус улсад тухайн хүний бие организм үүргээ биелүүлэх чадвараа алдсан хувиар тооцож 20-100 хувь хүртэл ангилан тогтоодог бөгөөд 50 хувиас доошгүй ХБ-ийг хүнд хэлбэрийн ХБ гэж тооцон тусгай үнэмлэх олгодог байна. Хүнд хэлбэрийн ХБИ-ийг 6 сараас дээш хугацаагаар ажилласны дараагаар ажлаас халах бол иргэдийн нутгийн холбоо, ХБ иргэд, ажил олгогчдын зөвлөлдөх албаны зөвшөөрлийг заавал авна. Ажил олгогч хуулиар заасан үүргээ санаатай болон санамсаргүй зөрчсөн тохиолдолд 2500 евро хүртэл торгох шийтгэл ногдуулна. Хүнд хэлбэрийн ХБ иргэдэд зориулсан тусгай газруудад ажил хөдөлмөр эрхлэх эрхтэйгээс гадна тусгай нөхөн сэргээх төвүүдэд өөрт тохирсон мэргэжил эзэмших эрхтэй. Мөн хувийн бизнесээ эрхлэх сонирхолтой ХБИ хөдөлмөрийн бирж ба интеграцын товчоогоор дамжуулан санхүүгийн дэмжлэг хүртэх эрхтэй.

Боловсрол эзэмших эрх

ХБНГУ-ын Үндсэн хуульд²⁰ бүх германчууд өөрсдийн мэргэжил, ажлын байр, боловсролын байгууллагыг сонгох эрхтэй. Нэг ч хүн хөгжлийн бэрхшээлтэйн улмаас эмзэглэх ёсгүй тухай Үндсэн хуульдаа тусгаж өгсөн. ХБНГУ-ын боловсролын хууль тогтоомжоор ХБИ нь дээд болон мэргэжлийн боловсролыг эзэмших эрхээр бусад хүмүүсийн нэгэн адил хангагдсан ба ихэнх дээд сургууль үнэ төлбөргүй байдаг. ХБИ-ийн сурах үйл явц, үр өгөөжийг дээшлүүлэх, зорилгоор тусгай тусламж авах эрхээр хангасан ба түүнд зарцуулагдах зардлыг холбооны муж улсын нийгмийн албад хариуцдаг. Харин ХБ оюутны эцэг эх, дундаж цалингийн хэмжээнээс дээгүүр орлоготой бол тусгай тусламжийн зардлын тал хувийг өөрсдөө хариуцна.

Мэргэжлийн сургалтын тухай хуулиар²¹ ХБ иргэдэд зориулсан мэргэжлийн сургалтын талаар зохицуулсан ба Мэргэжлийн сургалтад хамрагдсан хүмүүс нь мэргэшүүлэх сургалтад хамрагдах бөгөөд сургалтын агуулга нь хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий байдал, хөгжилд анхаарсан байх тухай заасан. ХБ суралцагч суралцах явцад тусламж үзүүлэх хувийн туслагч тодорхой хугацаагаар үйлчилж, тусламж үзүүлэхийг тусгай тусламж гэх бөгөөд энэ нь дадлагын ажил бичих, ном, сурах бичиг олох, дадлага хийх, хараагүй оюутанд хичээлийн материалыг уншиж сонсгох, сонсголгүйд нь хичээлийг нь тэмдэглэж өгөх, өөрөө явах, хөдлөх боломжгүйд нь сургуульдаа явж, хөдлөхөд нь тусалдаг. Туслагчаар оюутнууд болон сургуулийн дэргэдэх тусламж үзүүлэх зорилго бүхий албаны ажилтан байдаг байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Хууль зүйн салбарын хүрээнд

Хууль зүйн салбарт ХБ хүний эрх Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...", Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ..." гэж заасан үндсэн эрхүүд зөрчигдөж байгаа шалтгаан, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох иргэн, ТББ, хуулийн этгээдээс тодруулан, холбогдох хуулийг сонгон тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлэв. Тухайлбал:

[docs/BeschaefigungSchwerbehinderte.pdf](#)

²⁰ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland <https://www.gesetze-im-internet.de/gg/GG.pdf>

²¹ Berufsbildungsgesetz (BBiG) https://www.gesetze-im-internet.de/bbig_2005/BBiG.pdf

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

“Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйл.

Үнэлгээний зүйл 1

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль 6 дугаар зүйл.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хэл 2. Маргагч талууд монгол хэл мэдэхгүй бол түүнд хэлмэрчээр дамжуулан төрөлх буюу аль сайн мэдэх хэлээрээ ярих, ойлгох бололцоог Цэц олгоно. Хуралдаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад мэргэжилтэн монгол хэл сайн мэдэхгүй бол мэдүүлэг, дүгнэлт, тайлбараа төрөлх буюу сайн мэдэх хэлээрээ гаргаж хэлмэрчлүүлэх эрхтэй.
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 7 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг 7.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хэрэв хараагүй, хэлгүй, дүлий зэрэг шалтгааны улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар, мэдүүлэг өгөх, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх эрхтэй.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 1.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана.

Шалгуур үзүүдэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: Дээрх хуулиудаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч хэлмэрчийн тусламж авах эрхээр хангах зэрэг ХБХ шударга шүүхээр шүүлгэх, оролцох эрхийг хангасан зохицуулалтыг бий болгосон.

ШИГТГЭЭ

УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд 14 дэх зорилтод “хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулна” гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх тухай заасан байна.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Хэдийгээр шударга шүүхээр шүүлгэх, оролцох эрхийг хангасан зохицуулалтыг дээрх хуулиудад тусгасан боловч хуулийн хамгаалалт, баталгаа нь тэдгээрийг хангалттай хэмжээнд сахиулах, шаардлагатай материаллаг болон хүний нөөцөөр хангах, хүндэтгэн биелүүлэх явдал дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, ХБХЭТ хуулийн 27 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ХБХ эрх үүрэг болон холбогдох мэдээллийг ХБ-ийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгөх, эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах тухай заасан ч хэрэгжихгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

ШИГТГЭЭ

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, «Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбоо» ТББ-тай хамтран ажиллах гэрээг 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдөр байгууллаа.

(<http://bsch-districtcriminalcourt.gov.mn/main/2585.html> сүүлд үзсэн 2018.6.20)

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: ХБ хүний төлөөллийн байгууллагууд болон бусад дотоодын ба олон улсын байгууллагуудаас сонсголын бэрхшээлтэй хүмүүст дохионы хэлний хэлмэрчээр хангаагүй талаар шүүмжилдэг. МХҮХ, МТИҮН, МХБИНХ, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хороонд хүргүүлсэн тайланд дараах зүйлийг онцолжээ.

Хүчирхийллийн хохирогч болсон ХБХ, нэн ялангуяа сонсголын бэрхшээлтэй хүмүүс шүүх болон цагдаад хандах, боломжтой хэдий ч дохионы хэлний хэлмэрч байдаггүй. Иймд тэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй оролцох боломжгүйн улмаас хэргийг орхиж явах, шийдвэр гарахаас нь өмнө хэргийг хэрэгсэхгүй болгох хүсэлт гаргадаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу сонсголын бэрхшээлтэй хүмүүс эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд дохионы хэлний хэлмэрчийн тусламжийг авах боломжтой хэдий ч хуулиар хэн хэлмэрчийн зардлыг гаргах талаар заагаагүй тул эрх нь зөрчигдөж байдаг. Тухайлбал шоронд хоригдож байгаа сонсголгүй хүмүүс ихэвчлэн бусдад дарамтлуулж, хүчирхийлүүлж байдаг ба зарим тохиолдолд хийгээгүй хэргийн төлөө гэм буруутай болдог байна.²²

ХБХ шүүхийн хүртээмжийг баталгаажуулахад шаардлагатай процессын ажиллагааг хангасан тодорхой хуулийн заалт байхгүй байгаа нь хүндрэл учруулж байна.

Дүгнэлт, зөвлөмж. Шударга шүүхээр шүүлгэх, оролцох эрхийг хангасан зохицуулалт байгаа ч хараагүй хүн зөвхөн брайль уншиж чадах тул хангалттай мэдээлэл авч чадахгүй үлдэх, шүүхийн олон нийтийн мэдээллийн цонхоор үйлчлүүлж буй ХБХ мэдээлэл авч чаддаггүй зэргээр наад захын эрх нь зөрчигдөхөд дохионы хэл, брайлийн хангалттай байдал зэрэг хүртээмжийг дэмжсэн зүйл хийгдэхгүй байгаагаас үүдэн оролцох оролцоог хангах эрх зөрчигдөхөд хүрдэг тул ХБХ ялгаварлан гадуурхалтад өртөх явдал гарсаар байна. Иймд хууль сахиулах байгууллагууд, мэргэжилтнүүдийг шаардагдах сургалтад хамруулах зэрэг ХБХЭТ хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

ШИГТГЭЭ

Шүүхийн судалгааны тайлангийн эмхтгэлд Вашингтон мужийн шүүхийн хүртээмжийн товчооноос ХБХ тухтай үйлчлүүлж болох саналыг дэвшүүлсэн.

- Сонсголгүй бол дохионы хэлний хэлмэрчээр хангах,
- Харааны бэрхшээлтэй бол мэдээллийг том шрифтээр бичиж явуулах,
- Оюуны бэрхшээлтэй бол танин мэдэхүйн хэлмэрчийг ашиглахыг зөвшөөрөх,
- Шалтгаангүй айдас түгшүүртэй байдаг эмгэгтэй бол дагалдан явдаг тэжээвэр амьтантай нь хамт байхыг зөвшөөрөх
- Шээсний замын өвчтэй бол шүүх хуралдааны үеэр аль болох ойрхон ариун цэврийн өрөө явах завсарлага гаргаж өгөх,
- Нурууны гэмтэлтэй бол налуу түшлэгтэй сандлаар хангах,
- Хөдөлгөөний бэрхшээлтэй бол архитектур байгууламжийн зарим саадыг арилгах
- Ноцтой тархины гэмтэлтэй бол урт үргэлжлэх асуултыг хэд хэдэн жижиг асуулт болгон тавих

Сурах чадваргүйгээс уншиж чадахгүй өвчтэй бол бичгээр үйлдсэн мэдээллийг амаар уншиж танилцуулах зэргийг санал болгосон байна. Эдгээр саналыг харгалзан үзэж хэрэг хянан шийдвэрлэх явцад ХБХ эрхийн тэгш оролцоог нэмэгдүүлэх боломжтой юм.

²² Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхтгэл. УБ., 2016 он. 21 дэх тал.

Үнэлгээний зүйл 2

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль

7 дугаар зүйл. Яллагдагчийн төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох

7.1. Төлбөрийн чадваргүй яллагдагчид гэмт хэрэгт холбогдсон дараах хүн хамаарна:

7.1.3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

Шалгуур үзүүлэлт. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Хуулийн 3 дугаар зүйлд “төлбөрийн чадваргүй яллагдагч” гэж энэ хуулийн 7.1-д заасан хүнийг ойлгох тухай харин 7 дугаар зүйлд гэмт хэрэгт холбогдсон Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” байх тухай тодорхойлсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг ойлгох тухай заасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйлд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээнд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавих бөгөөд гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах талаар зохицуулсан боловч “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэмт хэрэгт холбогдсон бол Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиар “төлбөрийн чадваргүй яллагдагч” байх тухай тодорхойлсон нь хэл зүй, найруулгын хувьд алдаатай, ойлгомжгүй байдлаар томьёолсон нь хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй зохицуулалт болжээ.

Дүгнэлт. Зөвлөмж. Хүүхэд хамгааллын тухай хуулийн зохицуулалтаас харвал эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хөндийрүүлэн хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах зорилгоор гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд туслах, хамгаалах, хууль ёсны төлөөлөгчийг томилуулахад чиглэсэн асуудлыг зохицуулах байтал Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэмт хэрэгт холбогдсон нь “төлбөрийн чадваргүй яллагдагч” байх тухай заасан нь хэл зүй, найруулгын хувьд алдаатай, ойлгомжгүй байдлаар томьёолсон төдийгүй гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, хохирогч, болон бусад этгээд, иргэний болон захиргааны хэргийн тухайд төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхгүй байх тул “яллагдагч” гэдгийг “хүнд” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй байна.

3.2. Боловсролын салбарын хүрээнд

Боловсролын салбарын тухай хууль тогтоомжид ХБХ сурч боловсрох эрхийг хөндсөн, зөрчсөн аливаа ялгаварлан гадуурхсан зүйл заалт шууд утгаараа тусгагдаагүй байгаа боловч ХБХ сурч боловсрох эрх бусад хүүхдийн адил бүрэн дүүрэн хангагдах нөхцөл бий бололгүй зөрчигдөж байгаа шалтгаан, тулгамдаж буй асуудлыг тодруулан холбогдох хуулийг сонгон, үндсэн агуулгаараа ижил хуулиудыг багцлан дараах байдлаар хэрэгжилтийг тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлэв.

1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:
 - Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг,
2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:
 - Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэг,

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалт,

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйл.

Үнэлгээний зүйл 1

Боловсролын тухай хууль

4 дүгээр зүйл. Боловсролын зорилго

4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Шалгуур үзүүлэлт. Зорилгод хүрсэн түвшин

Монгол Улс боловсролоор дамжуулан “оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай иргэнийг төлөвшүүлэх зорилготой” тухай заасан байна.

Хуулийн зорилтод тусгасан боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах тухай заасан нь 2002 оноос өнөөг хүртэлх хугацаанд иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэжээ. Энэхүү хуулийн зорилго ердийн хүүхдийн тухайд хэрэгжилт нь хангагдан үйлчилж байдаг бол ХБХ тухайд төдийлөн эрх нь хангагдахгүй байна.

2002 онд батлагдсан Боловсролын тухай хуулийн 90 хувиас дээш зүйл, заалтад 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нэг заалтыг 6 удаа өөрчилсөн байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараа сурч боловсрох үндсэн эрхийг хангах хууль тогтворгүй үйлчилж байгаа төдийгүй дараах зөрчил дутагдалтай байна.

- ХБХЭТ хуультай холбоотой Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэж ХБХЭТ хуулийн 3.1 дэх хэсэг”-ийг удирдлага болгосонд энэ тухай ХБХЭТ хуульд заагаагүй байна.

- Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн “ХБХЭТ хуулийн 7.8-т” гэж ишлэсэн нь ХБХЭТ хуульд энэ тухай заагаагүй,

- Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, ХБ суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх” тухай заасан байна. Гэвч ердийн сургалттай сургуульд орох шат, орчин нөхцөл ХБ суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцээгүй нь хүндрэлтэй хэвээр байна.

ШИГТГЭЭ

БСШУЯ-ны 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр Монгол Улсын хэмжээнд 551.953 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, 243.432 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцаж байгаагаас ХБ 1.513 хүүхэд байна. Үндэсний хэмжээнд 6 тусгай сургууль байгаагаас харааны бэрхшээлтэй хүүхдийн 1, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 1, оюуны ХБ хүүхдийн 4 тусгай сургуульд нийт 1.621 хүүхэд суралцаж байна¹

Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны судалгаанд “ХБ хүүхдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, сургуулийн бага ангид суралцаж байдаг бол цаашид энэ хувь буурсаар ерөнхий боловсролын дунд, ахлах ангид суралцаж байгаа ХБ хүүхдийн тоо нийт ХБ хүүхдийн 14 хувь болтол буурдаг мэдээ байна.

Дүгнэлт, Зөвлөмж. Хүний сурч боловсрох үндсэн эрхийг хангахад чиглэсэн гол хууль болох Боловсролын тухай хуулиас “Боловсролын зорилго”-ыг авч үзэж судлагдахуунаа болгосон нь Монгол Улсын хүүхэд бүрийн сурч боловсрох эрхийг хангах, төлөвшүүлэн хөгжүүлэх мэдлэгтэй, мэргэжилтэй хүнийг боловсруулан гаргах чухал асуудал тул ХБХ сурч боловсрох эрхийг бусад хүүхдийн адил хангах нь зүйтэй юм. Боловсролын тухай хуульд ХБХЭТ хуулийн нэрэнд өөрчлөлт оруулсан хэдий ч эшлэл авсан заалтыг өөрчлөөгүй, мөн хуулийн 42 дугаар зүйлд заасан хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Үнэлгээний зүйл 2

Бага, дунд боловсролын тухай

12 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургууль

12.9.Ерөнхий боловсролын сургуульд суралцах ХБ хүний насны зөрүүг боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. /Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: Бага, дунд боловсролын тухай хуулиар ХБ хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байх тухай заасан бөгөөд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллах тухай заасан.

Хуулиар бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмших эрхийг хязгаарлаагүй тул ХБ хүүхдүүд ЕБС сурч төгссөөр ирсэн. Тухайлбал 1964 онд хараа сонсголын согогтой хүүхдийг боловсролд хамруулах үүднээс тусгай сургалттай 29 дүгээр сургууль байгуулагдсан нь тусгай хэрэгцээт хүүхдэд боловсрол эзэмшүүлэх эхлэл болсон юм. 1967 онд тусгай сургалттай 25 дугаар сургууль байгуулагдсан²³ нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээнд хамруулах нөхцөл бүрдүүлсэн. ХБ хүүхдүүдийг бусад хүүхдүүдээс тусгаарлан тусгай сургалттай сургуульд боловсрол эзэмшүүлж байсан нь 1990 оноос хойш боловсролд тэгш хамруулах, тэднийг нийгэмшүүлэх зорилгоор ердийн сургалттай сургуульд бусад хүүхдийн хамт сургах боломжтой болсон.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Тэргэнцэртэй, сонсголын бэрхшээлтэй, хараагүй, саажилттай зэрэг хүүхэд ердийн сургуульд суралцах орчин бүрдэж байгаа хэдий ч сургуулийн орох хаалганы шатнаас эхлэн бэрхшээлийг өдөр бүр, цаг минут тутамд даван туулах нь хүүхэд өсөж томрох тусам халшран зугтаах, нийгмээс тусгаарлагдах шалтгаан болсоор байна. Мөн хуулиар хүүхдийн ХБ-ийн онцлогийг харгалзалгүйгээр насны зөрүүг тогтоож өгөх тухай заах нь улиран сурах хүүхэдтэй дүйцүүлэн хүүхдүүд дунд ялгаварлан гадуурхалтыг бий болгох сөрөг үр дагавартай төдийгүй боловсролд тэгш хамрагдах эрхийг зөрчиж байгаа явдал нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудал болоод байна.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: ХБ хүүхэд гэдэг өргөн ойлголттой нэр томъёо учир бие эрхтний согогтой хэдий ч оюуны хөгжлийн хувьд бусад энгийн хүүхдийн түвшинд байдаг. Зарим тохиолдолд илүү сурах боломжтой. Тухайлбал, тэргэнцэртэй хүүхэд байнгын суугаа байгаа нь тэднийг суулгаж сургах шаардлагагүй тул бичих, бодох, унших хичээлд суралцах чадвар, хугацааны хувьд илүү боломжтой юм. ХБ ч үе тэнгийн хүүхдүүдээс хоцрохгүйг хичээн суралцах хүүхдэд орчин нөхцөл бүрдээгүйгээс үүсэх хүндрэлтэй асуудлыг даван туулах гэж хичээж байх явдлыг дэмжин туслах байтал насны зөрүүтэй, хоцрогдолтой суралцагч гэж ялгамжтай

²³ Нээлттэй нийгэм форумын бодлогын судлаач Л.Золбаатар “Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх”. УБ., 2006 он

хандах нь тэдний эрхийг зөрчсөн үйлдэл болох тул хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хуулийн заалт болжээ.

ШИГТГЭЭ

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт (UPR - Universal Periodic Review) НҮБ-ын ХБХ-ний эрхийн хороо 2015 оны 5 дугаар сарын 13-нд Монгол Улсын Засгийн газарт дүгнэлт зөвлөмжөө хүргүүлсэн. Зөвлөмжид ХБХ боловсрол эзэмших эрхэд онцгой анхаарал хандуулах тухай дурдсан.

- Сургууль, цэцэрлэгийн орчныг ХБ хүүхдэд ээлтэй хэлбэрээр засан тохижуулах, сургалтын бааз, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг бодлогын түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх;

- ХБ хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжихэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, шаардлагатай сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, хэрэгжүүлэх;

- ХБ хүүхдэд багшлах боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тэдний хөдөлмөрийн нөхцөл, цалин, урамшууллыг боловсронгуй болгох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах;

Дүгнэлт, Зөвлөмж. Бага, дунд боловсролын тухай хууль, Боловсролын тухай хуулиар заасан эрхийг ханган биелүүлэх, хариуцлага тооцох механизмыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх нь нэн чухал бөгөөд ХБХ насны зөрүүг тодорхойлон ялгаварлан гадуурхалтыг бий болгосон байна.

Иймд хуулийн зохицуулалтыг өөрчлөн найруулж ХБ хүүхдийн сурах орчин нөхцөлийг /шалгалт авах цаг хугацаа, багшийн илүү цаг зарцуулалт, тоног төхөөрөмж зэрэг асуудлын талаар шийдвэрлэх зэрэг/ бусад хөгжингүй орны түвшинд хангах нь боловсролд тэгш хамруулах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх энгийн хүүхдийн түвшинд өөрийгөө ямар нэг хэмжээгээр ХБ гэдгээ мэдрэхгүй өсөх хандлага төлөвшүүлэх мөн ХБ-ийг зөв оношлон тодорхойлох, суралцах идэвх сонирхолтой хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс үл хамааран дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна.

ШИГТГЭЭ

ХБ хүүхдийн суралцаж буй нийслэлийн 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургуулиас харааны бэрхшээлтэй хүүхдийн сургууль 1, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургууль 1 бусад нь оюуны ХБ хүүхдийг сургадаг байна.

Үнэлгээний зүйл 3.

Сургуулийн өмнөх боловсролын тухай

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.14. “халамжийн цэцэрлэг” гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг; /Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар/

Хүүхэд харах үйлчилгээний тухай

5 дугаар зүйл. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдагч

5.1. Хүүхэд харах үйлчилгээнд хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх насны хүүхэд хамрагдана.

5.2. ХБ хүүхдийг нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно.

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр “халамжийн цэцэрлэг” гэсэн нэр томъёог СӨБ тухай хуульд нэмсэн. Үүнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-дэх заалтад “нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг,

туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа ойлголтыг тодорхойлсон.

2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг батлан гаргасан бөгөөд 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Хуулийн 3 дугаар зүйлд “хүүхэд харах үйлчилгээ” гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амраах үйл ажиллагааг ойлгох тухай заасан.

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: 2016 онд СӨБ тухай хуулиар амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, халдашгүй чөлөөтэй байх үндсэн эрхээ сургуулийн өмнөх насны хүүхэд бүр эдлэх боломжийг нэмэгдүүлсэн. СӨБ хоёр наснаас эхлэх тухай заасан ч заавал 2 нас гэж хязгаарлаагүй бөгөөд СӨБ тухай хуулийн 9 дүгээр зүйлд “цэцэрлэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд үндэслэн ...хоёр хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж болно” гэж заасан. Хүүхэд харах үйлчилгээ, хувийн цэцэрлэг, сувилал, асрамжийн цэцэрлэгт 2 хүртэлх насны хүүхэд, ХБ хүүхэд хамрагдаж болдог байна.

Халамжийн цэцэрлэгийн тухай заалт 2016 онд нэмэгдсэн нь хүүхдийн халамжийн ажлыг хүүхэд хөгжүүлэх (оюуны, бие бялдрын г.м хөгжил) ажилтай нэгтгэх эерэг үр дагавар бүхий зохицуулалт болсон.

ШИГТГЭЭ

Нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн Ч.Билэг-Оюун “Нийслэлийн хэмжээнд ясли, цэцэрлэгийн гурван цогцолбор бий. Эмч, сувилагч нар ажилладаг учраас сургалт явуулах боломжгүй. Жил бүр тэрбум орчим төгрөг төсөвлөдөг. Сувиллын чанартай байсан ч цэцэрлэг гэсэн нэр томьёонд багтаж явдаг.

Нэг хүндрэлтэй асуудал нь ТЭМҮ гэсэн ангиллаар цалинжих ёстой хүмүүс боловсролын салбарын хуулийн дагуу цалинждаг. Уг нь бол Эрүүл мэндийн салбарынхаа хуулийн дагуу тэтгэвэр тэтгэмжээ тогтоолгох ёстой. Гэтэл боловсролын байгууллагад ажиллаж байгаа учраас манай салбарын хуулиар зохицуулагддаг.

Өнөөгийн байдлаар улсын гэгдэх 2 нас хүртэлх хүүхэд өсгөн хүмүүжүүлэх газар сувиллын, асрамжийн үүрэгтэй 3 хүрэхгүй /10-р цэцэрлэг нураасан байдалтай/ тооны цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бол 1990 он хүртэл 600 орчим хүн амтай нийслэлд 3 нас хүртэлх хүүхдийн ясли 40 гаруй байсан.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Нийгмийн асаргаа, сувилгаа, халамж шаардлагатай 2 хүртэлх насны болон ХБ хүүхэд бодит байдалд тусгай, асаргаа, сувилгаа, хувийн, хандивын хэв шинж бүхий байгууллагад харьяалагдах бөгөөд төрийн үйлчилгээ үзүүлдэг цэцэрлэг цөөхөн байна. Мөн ХБ хүүхдийн цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: СӨБ тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан 2 хүртэлх насны болон ХБ хүүхэд нь нийгмийн халамж шаардлагатай хүүхэд бөгөөд тэд төрсөн цагаасаа асаргаа, сувилгаа бүхий байгууллагад харьяалагдан үйлчлүүлдэг. Тэднийг эрт илрүүлэн боловсролд тэгш хамруулах боломж бүрдүүлэх, энгийн хүүхдийн түвшинд өсөж хөгжих боломж хязгаарлагдаж байна.

Б.Гандолгор. Засгийн газрын мэдээ. 2015-04-28. Хуулиас арчигдсан нэр: Ясли. Эрүүл мэнд, спортын яамныхан манай харьяаны газар биш гэж алдална. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нялх хүүхдэд боловсрол олгодоггүй учраас бидэнд хамаагүй гэнэ. (<http://news.gogo.mn/r/161002>сүүлд үзсэн 2018.6.20)

Дүгнэлт, Зөвлөмж. Манай улсад тусгай цэцэрлэг, сувиллын цэцэрлэг, асрамжийн цэцэрлэг, халамжийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ, хувийн цэцэрлэгүүдийн яслийн насны хүүхдэд, ХБ хүүхдэд үзүүлэх үйлчилгээ хүртээмжгүй, тэдний оюуны хөгжилд анхаардаггүй байна. Олон улсад хүүхдийг эхийн хэвлийд байх үед

оношлох, эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол сургалтын үйлчилгээг хамтад нь үзүүлэн хүүхдийн эсэн мэнд өсөн бойжих, хүн амын хөгжлийн бодлого, хүний аюулгүй байдалд тусгайлан анхаарал хандуулж байна. Тиймээс 2 хүртэлх насны хүүхэд болон ХБ хүүхдийн хэрэгцээг үнэлэн тэднийг хамгаалах, зөв хүн болгон нийгэмшүүлэн өсгөх, эрт илрүүлэн оношлох, эмчилгээ, сувилгаа, халамжийг үзүүлэх төрийн үйлчилгээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Нэгэнт халамжийн цэцэрлэгийн тухай заалтыг СӨБ тухай хуульд суулгаж өгсөн тул хэрэгжилтийг хангах нь зүйтэй байна.

НҮБ-ын Хүн амын сангаас 2013 онд хийсэн судалгаагаар харах хүнгүйгээс болж жилд 95 буюу сард дунджаар 15 хүүхэд энддэг. ХБ хүүхдийн 3 хүүхэд тутмын нэг нь олдмол ХБ байгаа нь хүүхдийг ХБ болохоос сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг сануулсан байна. (<http://mongolnews.mn/1fo2> сүүлд үзсэн 2018.6.20)

3.3. Хөдөлмөрийн салбарын хүрээнд

Хөдөлмөрийн салбар дахь хууль тогтоомжоор ХБХ эрх зөрчигдөж байгаа шалтгаан, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох иргэн, төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс тодруулан, холбогдох хуулийг сонгон үндсэн агуулгаараа ижил хуулиудыг багцлан, хэрэгжилтийг тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлэв.

1. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг,

2. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар бүлгийн 10.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,

Үнэлгээний зүйл 1

Хөдөлмөрийн тухай 111 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр 111.1.25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд ХБ буюу одой хүнийг ажиллуулна. /Энэ хэсэгт 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хууль, 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 15 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 15.1.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор энэ хуульд зааснаас гадна дараах дэмжлэг үзүүлнэ: 15.1.5.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ХБИ, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 16 дугаар зүйл. ХБИ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага 16.1.ХБ иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна.

Шалгуур үзүүлэлт. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд 2003 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд ХБ буюу одой хүнийг ажиллуулах тухай заасан.

Аж ахуйн нэгж, байгууллага ХБ буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд төлдөг төлбөр нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-д төвлөрч, ХБ буюу одой хүний нийгмийн хамгааллын арга хэмжээнд зориулагдаж

тэдгээрийг давтан сургах, ажлын байраар хангах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зээл олгох зэрэг арга хэмжээнд зарцуулагддаг. ХБИ ажиллуулаагүйн төлбөрт төвлөрдөг хөрөнгө нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ХБИ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулж байгаа хөрөнгийн 25-30 орчим хувийг эзэлж байна.

ШИГТГЭЭ

Ононгийн Ичинхорлоо. /Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс ХБИ асуудал хариуцсан референт/ Хөдөлмөрийн харилцаанд дахь квотын асуудал байдаг. Энэ нь байнга асуудал дагуулсаар ирсэн. Хөдөлмөрийн тухай хуульд зохицуулсан асуудлыг байгууллага тэр бүр хэрэгжүүлдэггүй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар ХБИ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр ХБИ-ийг ажлын байраар хангасан ажил олгогчдод, ХБ иргэнд санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах тухай хуульчлан зааж хэрэгжүүлж байна.

ШИГТГЭЭ

Манай улсад 103,6 мянган ХБХ байгаагийн хөдөлмөрийн насны 73,2 мянган иргэн байна. Үндэсний статистикийн хороо 2017 оны тоон мэдээ.

ХБИ боловсролын түвшинг нэмэгдүүлэх, ур чадвар, мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээлд тохирсон ажил алба эрхлэх, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, ХБИ тохирох ажлын байрыг судлан нэмэгдүүлэх, ХБИ өвчний оношийг хөдөлмөр эрхэлж болох ажлын байртай уялдуулан гаргах зэрэг байнгын асаргаатай, өвчтэй иргэдээс бусад ХБХ-ийг нийгэмшүүлэн ажиллуулах, ажиллаж хөдөлмөрлөх үндсэн эрхийг хангах нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар аж ахуйн нэгж байгууллагад ХБИ ажиллуулсан тохиолдолд урамшуулах, ажиллуулаагүй тохиолдолд төлбөр ногдуулах гэсэн хөшүүргийг хэрэглэж байгаа нь сайн талтай хэдий ч тэр бүр ХБХ-ийг ажилд бүрэн хамруулж хамт олны дунд оруулан нийгэмшүүлэх боломжийг олгохгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрсөн хөрөнгөөс ХБИ санхүүжилт авснаар өөрийн бизнесийг хийх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан орчин нөхцөлийг өөртөө бий болгон ажиллаж байгаа нь ажил олгогчтой хамтран ажилласан тохиолдлоос илүү байна.

Сэргээн засах үндэсний хөгжлийн төв нь²⁴ /СЗҮХТ/ суралцаж төгссөн хүмүүсээс судалгаа авсан байгаа нь өнөөгийн ХБИ хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа шалтгааныг тодорхойлж байна.

ХБХ-ийг “ажилд авдаггүй” гэсэн хариултыг ихэнх нь өгсөн байгаа нь хөдөлмөр эрхлэхгүй байх шалтгаан болж байгаа төдийгүй Мөн ажилд ордог хэдий ч буцаад гарах нь хурдан байдаг тул ажлаас гарсан шалтгааныг тодруулсан судалгаанд “хүнтэй ойлголцдоггүй” гэсэн байна.

Дүгнэлт, Зөвлөмж. ХБИ ажилтай, орлоготой байлгах, нийгэмшүүлэх талаар арга хэмжээ авдаг ч тэднийг ХБ онцлогт тохирсон эрүүл мэндийн байдал, хөдөлмөр эрхлэлтэд тохирох ажлын байрны судалгаа явуулах хэрэгцээ шаардлага байгаа юм. Тэдний хөдөлмөр эрхлэх, бусадтай адил ажиллаж амьдрахад шат, замын хашлага, тээвэрлэлт, гэх мэт тохируулгатай орчин нөхцөл шаардлагатайгаас бусад тохиолдолд бусдаас ялгагдах зүйлгүй хөдөлмөрлөх боломжтой. Хуулиар ажил олгогч ажлын байранд тэнцүүлэн авдаг, тэднийг урамшуулах, торгох тухай ойлголтыг халж, мэдлэгтэй, боловсролтой, чадвартай ХБХ-ийг дэмжих, нийгэмшүүлэхийн зэрэгцээ ХБИ зориулсан тохирох ажлын байрыг бэлдэх, орчин нөхцөлийг саадгүй болгох

²⁴ Б.Дэлгэржаргал. СЗСҮТ., “Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй зарим асуудлуудыг судлах” УБ.,2017 он. https://nrc.gov.mn/disability_studies/ сүүлд үзсэн 2018.6.15

шаардлагатай тул квот тогтоож хүчээр хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх нь нийгэмд бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй байна.

Үнэлгээний зүйл 2

Зөрчлийн тухай хууль

Аравдугаар бүлэг. Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил
10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих

1. Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд ХБ, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шалгуур үзүүлэлт. Зорилгод хүрсэн түвшин

Зөрчлийн тухай хуулийн дээрх заалт нь ХБХ-ний хөдөлмөрлөх эрхийг хангах зорилгыг агуулсан боловч ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд ХБ, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх тухай заасан нь ХБИ ажилтай байлгах зорилгоос илүүтэй төлбөр торгууль ногдуулах асуудалд илүүтэй анхааран үндсэн зорилгод хүрэх зохицуулалт энэ хуулиар болон бусад хуулиар хангалттай олгогдоогүй байна.

ШИГТГЭЭ

2017 оны 10 дугаар сарын байдлаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас ХБИ хөдөлмөр эрхлэлтийн байдалд 636 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан шалгалт хийжээ. Шалгалтад 192 нь ХБИ зохих орон тоонд ажиллуулаагүй, ажлын байрны төлбөрийг төлөөгүй байна. Улсын байцаагчийн 116 акт үйлдэж 348 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьснаас 97 байгууллагад 277 сая төгрөгийг ХБИ хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн байна. Мөн 125 аж ахуйн нэгж, байгууллагад 25.4 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулж, 100 аж ахуйн нэгжид 6 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн байна. (ХНХЯ. ХБИ-ийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах. 2017 он.)

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн санд орлогыг төвлөрүүлж байнгын ажлын байртай байх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч нийгэмшүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх эрхийг тэгш хангахаас илүү хувиараа хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдэхэд хүргэж байна.

ШИГТГЭЭ

Одоо хөдөлмөрийн зах зээл дээр 18 мянга орчим ХБХ ажиллаж байгаагийн 16 мянга гаруй нь өөр өөртөө ажлын байр гаргах буюу өрх, бүлэг, бичил бизнес эрхэлж байна. (ХНХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Германы GFA компанийн хэрэгжүүлж байгаа Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл “ХБИ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АРГА, ХАНДЛАГА” 2017 он. 84 дэх тал)

Дүгнэлт, Зөвлөмж. ХБХ нийгэмшүүлэх, ажил хөдөлмөрөөр хангагдахаас илүү хувиараа хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдэж байх тул албан тушаалын 4 буюу түүнээс дээш орон тоонд ХБХ ажиллуулаагүй тохиолдолд төлбөр авах тухай заалт үндсэн зорилгодоо хүрч чадаагүй. Өөрөөр хэлбэл, ХБХ-ийг ажилтай байлгах аас илүү санд хөрөнгө төвлөрүүлэх заалт болсон тул үндсэн зорилгод хүрэх агуулгыг тусгасан зохицуулалт байх нь зүйтэй байна.

Тухайлбал, ХБХЭТ хуулийн 17 дугаар зүйлд заасан хөдөлмөрлөх эрхийг ханган үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалт, энэхүү хуулийн бусад зүйл, заалтад туссан хориглосон, үүрэгжүүлсэн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагыг тусгаагүй байна. Энэ нь тэдний ажиллах хөдөлмөрлөх эрхээ хангах хүртээмжтэй орчин бий болгох, нийгэмшүүлэх, тохирох ажлын байранд аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтад өртөхгүй бусдын адил хөдөлмөр эрхлэх боломжийг хуулиар олгосон хэдий ч зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бий болоогүй байгаа юм. Тиймээс Зөрчлийн

тухай хууль болон Эрүүгийн хуулиар үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг тооцох нь зүйтэй гэж үзэж байна.

3.4. Дэд бүтцийн салбарын хүрээнд

Дэд бүтцийн салбар дахь хууль тогтоомжоор ХБХ эрхийг хуулиар дэмжсэн, норм, дүрэм журмыг батлан хэрэгжүүлэх тухай заасан. ХБХЭ-ийг бүрэн дүүрэн хангах нөхцөл бүрдээгүй зөрчигдөж байгаа шалтгаан, тулгамдаж буй асуудлын талаар тусгасан холбогдох хуулийн хэрэгжилтийг тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлэв.

“Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт, “Практикт нийцэж байгаа байдал.” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:
- Авто тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалт.
- Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт.

Үнэлгээний зүйл 1

Авто замын тухай 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.11. “замын байгууламж” гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, ХБХ зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг;

Шалгуур үзүүлэлт. Хүлээн зөвшөөрөгдсөн эсэх

Авто замын тухай хуулиар “Замын байгууламж” гэдэгт “...ХБХ зорчиход зориулсан зам” байх тухай, мөн замын байгууламжийг барьж байгуулах талаар төрөөс авто зам, замын байгууламжийг эрх бүхий байгууллагаар батлагдсан стандарт, норм, нормативын дагуу барьж байгуулах зарчмыг баримтлах бөгөөд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, норматив, техникийн баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, авто замын арчлалт, урсгал засварын ажлыг хийдэг байна.

ХБ хүн зорчиход зориулсан замын байгууламжийн талаар зохицуулалт байгаа хэдий ч ХБ иргэний хэрэгцээг хангахгүй, зорчиход хүндрэлтэй байгаа нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

ШИГТГЭЭ

ХНХЯ-ны ХБИ асуудал хариуцсан мэргэжилтэн Тогтохын Мөнгөнцэцэг. Ярилцлагын хэсгээс. “Тэргэнцэртэй хараагүй хүмүүс нийгмийн амьдралд оролцоод хувь нэмрээ оруулаад явна гэхээр заавал нэг хүнээр түрүүлж юмуу хөтлүүлж явдаг, ...тэргэнцэртэй хүмүүст налуу зам, харааны бэрхшээлтэй хүнд таягтай явахад зориулагдсан зам, ...нийгмийн харилцаанд, нийгмийн амьдралд оролцож чадахгүй болохоороо нийгмээсээ хоцорч байна.

ХЭҮК-ын референт Б.Сэмжидмаа “Мөн 100 айлын гүүрэн гарц дээр харааны бэрхшээлтэй хүний замыг шийдсэн боловч замын төгсгөлийг гүйцэд зааж өгөөгүйгээс чигээрээ явсаар байгаад зам тээврийн осолд өртөх магадлалтай байна.”

Д.Гэрэл МХҮХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга “Ярьдаг гэрлэн дохио 3 газар тавигдсан нь хүмүүсийн амгалан тайван байдал алдагдаж байна гээд дууг нь хаасан нь олон улсын жишигт нийцээгүй зүйл хийгдэж хөрөнгө мөнгө үрсэн учир цаашид хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй”,

Хараагүй иргэний ярилцлага. “Олон удаа траншений нүхэнд унаж байсан.”

“Бэрх зам ба ХБ хүүхдүүд” Гадуур гарч орох асуудал бүрд шат, замын хашлага, замын байгууламж зэрэгт заавал хэн нэгэн хүний туслалцаа хэрэгтэй болдог нь нийгмээс тусгаарлан ялгаварлан гадуурхалтад өртөхөд хүргэдэг тухай. /www.youtube.com/

Дүгнэлт, Зөвлөмж. Шинээр ашиглалтад орсон ХБИ зорчих замын хэсэг шаардлага хангаж байгаа хэдий ч ХБХ бусад иргэдтэй нэгэн адил эрхээ эдлэх, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад хүндрэлтэй хэвээр байгаа тул хуучин замын асуудлыг шийдвэрлэх, хуулийг хэрэгжүүлэхэд тусгайлан анхаарал хандуулан тавигдах стандарт шаардлагад тусгаж хяналтыг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Үнэлгээний зүйл 2

Автотээврийн тухай хууль

10 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

10.2. Тээвэрлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

10.2.8. 20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь ХБИ-ийг тээвэрлэхэд зориулагдсан байх; /Энэ заалтыг 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн/

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: ХБИ нийтийн тээврээр зорчих эрхийг хангасан хуулийн заалт. Нийтийн тээвэрт орж суусны дараагаар ХБИ зориулсан харж унших, сонсож болох буудал зарлах тоноглол суулгасан, зарим автобусанд тэргэнцэртэй иргэд зорчих боломжтой болсон. (хотын төвөөр зорчих урт тээврийн хэрэгсэл)

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Тэргэнцэртэй болон ХБХ нийтийн тээврээр зорчих нь орж суух шатруу авирах, хараагүй иргэд ямар чиглэлийн нийтийн тээвэр ирж байгааг мэдэх боломжгүй гэх мэт сөрөг үр дагавар үүссээр байна. Нийтийн тээврийн 10-аас доошгүй хувьд ХБХ зориулагдсан байх тухай заасан нь бусад иргэдийн нэгэн адил зорчих эрхийг хязгаарласан нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт болжээ.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: Тээврийн хэрэгслийнхээ 10-аас доошгүй хувийг тусгайлан тоноглож бэлдсэн байх тухай заасан нь практикт нийцэхгүй зохицуулалт болсон. Компанийн тээврийн хэрэгсэлд ХБХ орж суухад зориулсан тээврийн хэрэгсэл цөөхөн байх бөгөөд 20 автобуснаас 2 нь тоноглогдсон байх тухай юм. Энэ нь ХБХ нэг шугаманд 2 автобус явах эсэх, явах бол хэр хугацаанд хүлээж суух боломжтой эсэх нь ойлгомжгүй тул энэ нь тэдний бусдын адил зорчих эрхээ эдлэхэд хүндрэл учруулаад байгаа юм.

Авто тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “тээврийн хэрэгсэлгүй бол ЗГ-аас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр төлбөр төлнө” гэж заасан.

ШИГТГЭЭ

“Түгээмэл төв” ТББ-ын менежер М.Чулуун-Эрдэнэ. Миний хувьд нугасны гэмтэл аваад 15 жил болсон ч сүүлийн арваад жил нийтийн тээврээр үйлчлүүлээгүй. Тийм боломж нөхцөл ч байдаггүйг та бүхэн мэднэ. Хэдий хуульд ХБИ нийтийн тээвэрт хөнгөлөлттэй, үнэгүй зорчих эрхтэй ч чухам яаж эдлэх, зорчих нь тодорхойгүй байна.

Тэргэнцэртэй иргэний ярилцлага: “Автобус буудал дээр ирсэн байхад очих гэсээр байтал явчихдаг, хүлээж байгаад суухдаа олон хүний дэмжлэг авдаг, ер нь их хүндрэлтэй тул аль болох гэрээсээ гардаггүй”,

“Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-ны тэргүүн Б.Чулуундолгор. ХБИ-дэд зориулан Нийтийн тээвэрт өгч байгаа нөхөн олговрын үр шимийг бид хэзээ ч хүртэж чаддаггүй. <https://ikon.mn/n/79>

Хараагүй иргэний ярилцлага: “Мэдэхгүй олон автобус дамжих үе олон гардаг, хүмүүс хэлж өгдөггүй, ажлаасаа хоцрох тохиолдол их байсан”. “Хүний эрх, миний эрх”- МҮОНТВ /Хүртээмжтэй орчин/ нэвтрүүлэг,

ХНХЯ-ны ХБИ-ний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болороо. /ХБИ/ “Орчны саад тотгорт тулснаар ХБ гэдгээ мэдэрдэг тул нийгмийн оролцоонд тэгш оролцож чаддаггүй...”

Дүгнэлт, Зөвлөмж. ХБ хүнийг нийтийн тээврээр зорчих эрхийг хангасан зохицуулалт тусгагдсан хэдий ч ХБИ бусад иргэдтэй нэгэн адил эрхээ эдлэх боломжгүй болоод байна. Ялгаварлан гадуурхалтад өртөхгүй нийтийн тээврээр зорчих боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2007 оноос өдийг хүртэл зохицуулагдаагүй ирсэн заалтыг өөрчлөн ХБИ-ийн эрхийг хангахад чиглэсэн харилцааг зохицуулах, хүндрэлтэй асуудлыг нарийвчлан авч үзэж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Үнэлгээний зүйл 3

Барилгын тухай 11 дүгээр зүйл. Барилгын үйл ажиллагааны зарчим 11.1.Барилгын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 11.1.6.ХБИ-ийн эрхийг хангах: барилга байгууламж ХБИ-ийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;
Хот байгуулалтын тухай 20 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох 20.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтална.

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: 2016 оны Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ХБИ-ийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдаж эрхийг хангасан байх тухай заасан нь шинэлэг зохицуулалт болсон.

2008 оны Хот байгуулалтын тухай хуулиар ХБИ нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журмыг баримтална гэж заасан зэргийг хангах зорилгоор 2017 оны Засгийн газрын 69 дүгээр тогтоолын хавсралт “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ээр ХБХ хэрэгцээ шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт хийх тухай заасан нь ХБХ эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг барилга хүлээж авах комиссоор оруулах тухай зохицуулсан.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Хуулиар барилга байгууламж нь ХБИ зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх тухай заасан хэдий ч Барилгын тухай хуучин хууль (нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн зураг төсөл нь барилгын норм, дүрэмд заасны дагуу тулгуур эрхтний согогтой тахир дутуу хүний хэрэгцээг харгалзан боловсруулагдсан байх), Хот байгуулалтын тухай зэрэг хуулиар заасан

барилгын норм, дүрэм стандартаар хэрэгжүүлэх явдал нь өнөөг хүртэл хэрэгжээгүй ирснийг шинэ Барилгын тухай хуулиар эрчимжүүлэх зүйл заалт тусгагдаагүй. Харин Засгийн газрын тогтоолоор хэрэгжилтийг хангах олон ажил хийж байгаагийн нэг нь Зөрчлийн тухай хуулиар өндөр хэмжээний торгууль ногдуулдаг, ХБХ эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг барилга хүлээж авах комисст оруулсан нь хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж байгаа хэдий ч 2017 оноос өмнөх баригдсан барилгын зөрчил дутагдлыг хэрхэн арилгах, ХБХ эрх ашигт нийцүүлэх талаар зохицуулагдсан зүйлгүй байгаа юм.

ШИГТГЭЭ

2017 оны Засгийн газрын 69 дүгээр тогтоол, Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолд ерөнхий зохицуулагдсан нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн барилга хүлээж авахдаа норм, дүрэм стандартыг мөрдсөн байхыг шаарддаг.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: ХБХ эрхийг хангах норм дүрэм, стандартууд байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь гол хяналт тавих байгууллага болох Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар заасан мэргэжлийн хяналтын байгууллага нь барилгын норм, дүрэм журамд зааснаар хяналт тавих боловч хуучин баригдсан барилгын шат, орчин нөхцөлийг ХБХ тохируулан өөрчлөх ажил хийгдэхгүй, энэ тухай харилцааг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулсан зүйлгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Дүгнэлт, Зөвлөмж. ХБИ эрхийг хангасан норм, дүрмийг мөрдүүлэх тухай заасан хэдий ч нэгэнт баригдсан барилгын ХБХ саад болж буй хэсгийг хэрхэн сайжруулах тухай зохицуулалт тусгагдаагүй байгаа тул хуулийг хэрэгжүүлэх, тавигдах стандарт шаардлагад тусгах нь зүйтэй байна.

3.5. Нийгмийн даатгал, халамж, хамгааллын салбарын хүрээнд

Нийгмийн даатгал, халамж, хамгааллын салбар дахь хууль тогтоомжоор ХБИ эрхийг бүрэн дүүрэн хангах нөхцөл бий болоогүй зөрчигдөж байгаа шалтгаан, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох хуулийн хэрэгжилтийг тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлэв.

“Практикт нийцэж байгаа байдал.” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйл.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 1 дүгээр зүйл.

Үнэлгээний зүйл 1

Нийгмийн халамжийн тухай

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.9.“төрөлжсөн асрамжийн үйлчилгээ” гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон ХБИ, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг;

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: Төрөөс асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон ХБХ, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа

сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд төрөөс тусгайлан анхаарч үйлчилгээ үзүүлдэг байна. Асрамжийн үйлчилгээг улс, бүс, орон нутгийн асрамжийн газар, тасаг үзүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага үзүүлж, сум, хорооны нийгмийн ажилтан зохион байгуулдаг байна. Манай улсад 1925 оноос хойш асрамжийн үйлчилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь ахмад настны, ХБ, хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамж, гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн төрөлтэй байх тухай заасан. Төрөөс ХБХЭ-ийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмшүүлэн хөгжүүлэх чиглэлийг баримталж байгаад төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нийцэхгүй байна.

ШИГТГЭЭ 4

Нийгмийн хамгааллын бодлого. АХБ, Дэлхийн банкнаас өгсөн мэдээллийн дагуу ХБ хүмүүст зориулсан нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдаас буюу 34,402 хүний 18% орчим (6065 хүн) нь хөгжлийн бэрхшээлгүй иргэд байна. Энэ нь одоогийн нийгмийн халамжийн төлбөр тооцооны системийн үр ашгийг сайжруулах зорилгоор аудит хийх шаардлагатайг харуулж байна. (Засгийн газраас ХБХЭ-ийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний 2017-2020 хөтөлбөрийн төсөлд тусгасан хувилбараас авав.)

Төрөлжсөн асрамжийн газар болох ахмадын асрамжийн газар нь ахмад настан, сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн үйлчилгээг үзүүлэхдээ тэдгээрийг нэг дор байрлуулсан нь амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх явдлыг тэр бүр хангасан байж чадахгүйд хүрээд байгаа юм.

ШИГТГЭЭ

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганболд (2018.2.7) Төв аймгийн Батсүмбэр сум дахь Ахмад настны үндэсний төв нь 1925 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд одоогоор 142 ахмад настан болон ХБИ байна. Тэдний 87 нь нийслэлээс, 55 нь хөдөө орон нутгаас ирсэн бөгөөд оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй 34 хүн байна. Хүндрэлтэй асуудлын талаар:

1. Сэтгэцийн өвчтэй хүмүүс нь бусад асруулагчдын ая тухыг ихээхэн алдуулдаг,
2. Яаралтай тусламж шаардлагатай, хүнд өвчтэй асруулагчдыг гурав дахь шатлалын эмнэлэгт үзүүлэхийн тулд харьяаллын дагуу Улаанбаатар хотын дундуур гарч, Төв аймаг орсны дараа эргэж нийслэлийг зорьдог,
3. Өдөр тутмын асаргаа, эмчилгээ шаардлагатай хэвтрийн 53 хүн байдаг нь сумын төвийн эмнэлгээс хэд дахин их ажлын ачаалалтай. Тиймээс цалингийн шатлал, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчилж өгөхийг тус төвийн дарга хүссэн байна. Эх сурвалж: (<https://dnn.mn/> ажлын-хэсэг-батсүмбэр-дэх-ахмад-настны-үндэсний-төвийн-үйл-ажиллагаатай-танилцлаа. сүүлд үзсэн 2018.6.20)

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: Ахмад настан, сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн үйлчилгээг нэг дор үзүүлж байгаа нь тэдний сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээг үзүүлэхэд тэдний эрх ашгийг дээдлэн, амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх боломжгүйд хүргээд байгаа, мөн ХБИ асрамж, хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, нас, хүйсийн онцлогийг харгалзан асрамжийн үйлчилгээг үзүүлэхгүй байгаа зэрэг нь хуулийн хэрэгжилтийн явцад хүндрэл учруулаад байна.

Дүгнэлт, Зөвлөмж. Манай улсад асрамжийн үйлчилгээний байгууллагын чиглэл нь өнөөгийн хүний тэгш эрхийг хангах олон улсын шаардлагад нийцэхгүй тэднийг нийгмээс ялгаварлан гадуурхсан байдалд хүргээд байна. Тиймээс зайлшгүй асаргаа шаардлагатай ахмад настан, ХБХ, хүүхэд зэрэгт үзүүлэх үйлчилгээг тэдгээрийн онцлог шаардлагад тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал: ХБХ тухайд нас, өвчний онцлогоос хамааран мөн тухайн хүний эрхийг хангахад хүрсэн үйлчилгээг төрөөс үзүүлэх зэргээр төрөлжсөн асрамжийн үйлчилгээг өөрчлөх нь зүйтэй юм.

Үнэлгээний зүйл 2**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай**

7 дугаар зүйл. Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх

1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан насанд хүрсэн ХБИ тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын улмаас байнга буюу удаан хугацаагаар алдсан тохиолдолд түүний хөдөлмөрийн чадваргүй байгаа хугацаанд, хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр тэтгэвэр олгодог байна.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Даатгуулагч ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох тухай заасан хэдий ч ЭМЯ-ны сайд, ХНХЯ-ны сайд хамтран 2017 онд даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн баталсан. Энэхүү жагсаалтаар ердийн өвчний жагсаалтыг баталсан байх бөгөөд тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын гэж хуваагаагүй бөгөөд халдварт өвчин, арьс өнгө, чих хамар хоолой гэх мэтээр 10 хэсэгт хувааж 200 гаруй өвчнийг 50 хувиас дээш хөдөлмөрийн чадвар алдалтад тооцсон. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан (70 хувь) тахир дутуугийн тэтгэвэр авагч нь шимтгэл төлж ажилласан эсэхээс үл хамааран 1 хувийн нэмэгдлийг авдаг бол тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлж буй хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан (69 хувиас доогуур) даатгуулагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон, илүү ажилласан жил тутам хөдөлмөрийн хөлсний 1.5 хувиар нэмэгдэл авч байгаа зэрэг нь тулгамдсан асуудал болоод байна.

ШИГТГЭЭ

Монголын ХБИ-ийн Нэгдсэн холбоо. Гүйцэтгэх захирал Л.Бат-Отгон ярилцлага. Нийгмийн даатгал төлсөн байдлаас ажил эрхэлсэн байдлыг харгалзан үздэг. Тэтгэвэрт гарах гэтэл ажилласан жил тооцогдохгүй. Тэтгэмжээр тооцогддог учраас нийгмийн даатгал хагас дутуу төлсний хэрэг гардаггүй. 70 хувьтай байгаа учраас нийгмийн даатгал төлж болохгүй байгаа тул нягтлан бодогч нь 69 болгоод ирээч гэсэн тохиолдол хүртэл байна.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмжийг олгох өвчин эмгэгийг тодорхойлохдоо эрүүл мэндийн эмгэг гэдэг утгаар тодорхойлсноос бус хөдөлмөр эрхэлж болох хүн, нийгмийн халамж хүртэх хэдий ч тодорхой хугацааны дараагаас хөдөлмөр эрхэлж нийгмийн харилцаанд орж болох хүн эсвэл байнгын асаргаа шаардлагатай өвчтөн гэдгээр тусгаарлаж гаргасан эрх зүйн зохицуулалтгүй байгаа юм. Энэ нь тэтгэвэр тогтоож байгаа хувь хэмжээгээр ХБИ-ийн эрх ашиг хөндөгдсөн (1хувийн зөрүү гарч), нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээг хэнд хүргэх нь ойлгомжгүй, байгаа төдийгүй 50 хувиас дээш тогтоолгосон өвчтөн бүр нийгмээс тусгаарлагдан ялгаварлан гадуурхагдаж болох хүндрэлтэй асуудлуудыг үүсгээд байна.

Дүгнэлт, зөвлөмж. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд даатгуулагч ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын улмаас байнга буюу удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд түүний, хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон

сар бүр тэтгэвэр олгодог хэдий ч 50 хувиас дээш хөдөлмөрийн чадвар алдалттай ХБИ нь өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо бүрэн алдалттай бол илүү ажилласан жил тутам 1 хувь, хэсэгчилсэн алдалт тутамд 1,5 хувь тооцож олгож байгааг өөрчлөх нь зүйтэй байна. ХНХЯ-ны нийгмийн даатгалын, тэтгэвэр тэтгэмжийн хуулиудад 2015 он, 2017 онд өөрчлөлт орсон боловч “тахир дутуу” гэдэг үгийг өөрчлөөгүй өдийг хүрсэн байна.

Үнэлгээний зүйл 3

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт. Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, төлбөр өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шалгуур үзүүлэлт. Зорилгод хүрсэн түвшин

Уг хуулиар өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан журмын даатгалд даатгуулах бөгөөд ажиллах явцад үүссэн үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртсөн, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан буюу мэргэжлээс шалтгаалсан өвчин туссан бол Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон хуульд заасан бусад зардлыг олгох харилцааг зохицуулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хүрээнд 2017 онд Тэтгэврийн даатгалын сангаас 67,9 мянган ХБИ 183 тэрбум төгрөгийн, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 4578 ХБИ 23,6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна.²⁵

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль нь ялгаатай зохицуулалтыг тусгасан. Гэвч Нийгмийн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлд 2008 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр эмнэлэг хөдөлмөрийн магадалгаа гаргах болсон бөгөөд ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах тухай зааж өгсөн нь үйлдвэрийн осол, ахуйн ослын талаарх ойлголтыг тодорхойгүй болгосон нь тулгамдсан асуудал болоод байна.

Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг баталсан нь мэргэжлийн хяналтын байгууллагаас ослыг бүртгэж акт тогтоох гол баримт бичиг нь үйлдвэрлэлийн осол, ахуйн осолд өртсөн иргэдийн хувьд бүрэн дүүрэн ойлголтыг авах нарийвчилсан харилцаа дутмаг байгаа юм.

²⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2018 оны анхны хуралдаан <http://hudulmur-halamj.gov.mn/news/show/id/753> сүүлд үзсэн 2018.6.22

ШИГТГЭЭ

Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол. 1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29.2-т заасны дагуу ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна. Гаргасан үйлдвэрлэлийн ослын актыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хурц хордлогын дүгнэлтийг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тус тус хянана.

Дүгнэлт. Зөвлөмж. Нийгмийн даатгалын тухай хуульд 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь "...ердийн болон мэргэжлээс шалтгаалах" өвчний улмаас хөдөлмөрийн чадварыг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно" гэж зохицуулсан хамтарсан сайдын тушаал болон Засгийн газрын тогтоолоор ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын талаар зохицуулсан зохицуулалт болон үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүссэн харилцаанд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай зохицуулалтыг хамтатгаснаас үүдэн хуулийн зорилгод хүрч бүрэн дүүрэн амьдралд хэрэгжихгүй байх тул үйлдвэрлэлийн осол, ахуйн осолд өртсөн өвчний талаар дэлгэрэнгүй зохицуулах нь зүйтэй байна.

1.6. Бусад салбарын хүрээнд**Үнэлгээний зүйл 1****ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ**

38 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

38.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах дараах барааг гаалийн татвараас чөлөөлнө:

38.1.12.зөвхөн тахир дутуу тэргэнцэртэй хүнийг суулгах, буулгах зам, тавцан, өргүүртэй, эсхүл ХБХ өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар ажиллагаатай, дээрхийн адил бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа;

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцэж байгаа байдал.

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: ХБ хүн өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар ажиллагаатай, дээрхийн адил бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг гаалийн татвараас чөлөөлөх тухай заасан нь Монгол Улсын ХБИ өөрийн хэрэгцээнд автомашин хэрэглэхийг зөвшөөрсөн төдийгүй жолооны сургалтад хамруулдаг болсон.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа гаалийн татвараас хөнгөлүүлэн оруулж ирэх тухай заасан. Өнөөгийн техник технологи хөгжиж байгаа үед "бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа" оруулж ирэх заалт байгаа нь энэ чиглэлийн авто машины хэрэглээ хөгжихгүй ХБИ боломжийг хязгаарласан нь тулгамдсан асуудал болжээ.

Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх: ХБИ бусдын адил хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхтэй бол бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа гаалийн татвараас хөнгөлүүлэн оруулж ирэх тухай заалт нь хэрэгжих боломж муутай байна.

Дүгнэлт, Зөвлөмж. ХБИ бусдын адил хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхтэй бөгөөд нэг хүнд нэг гэдэг заалтыг хасаж бүрэн тоноглогдон

үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг гаалийн татвараас хөнгөлүүлэн оруулж ирэх нь тэдний эрхийг хангах төдийгүй дэд бүтцийн хүндрэлтэй зарим асуудлыг ХБИ хувьд шийдвэрлэх давуу талтай.

Үнэлгээний зүйл 2

Олон нийтийн радио, телевизийн тухай

8 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого

8.1. Олон нийтийн радио, телевиз улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгоно.

8.2. Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараах бодлого баримтална:

8.2.7. үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ХБИ зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх.

Шалгуур үзүүлэлт. Зорилгод хүрсэн түвшин

ОНРТ-ийн тухай хуулиар монголын ард түмэнд үйлчлэх ОНРТ-ийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход хуулийн зорилго оршиж байгаа тухай заасан.

Хөтөлбөрийн бодлогын үндэс нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгох бөгөөд үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ХБИ зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахад чиглэгдэж байна.

Гэвч 2005 онд батлагдсан хуулийн зорилго одоог хүртэл бүрэн дүүрэн хэрэгжиж чадаагүй байна. МҮОНТ-ээс бусад телевиз мэдээллийн хөтөлбөр, нэвтрүүлгээ байнгын дохионы орчуулагчтай явуулдаггүй бөгөөд энэ нь сонсголгүй иргэдийн эрхийг зөрчиж мэдээлэл авахдаа ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа хэлбэр юм.

Хуулийн зорилго нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангаж ХБИ хүргэж байх тухай боловч бодит байдалд “Цагийн хүрд” хөтөлбөрөөс бусад нэвтрүүлэг дохионы орчуулагч, хэлмэрчтэй явагдах нь ховор байна.

Мэдээ орчуулдаг дохионы орчуулагч нь дэлгэцийн доод буланд харагдахаасаа харагдахгүй шахуу жижгээр гардаг нь учир дутагдалтай. Гадаадын орнуудад телевизийн экран буюу дэлгэцийн дөрөв хуваасны нэг тэр ч бүү хэл тал хэсэгт нь дохионы орчуулагч гаргадаг нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд тухайн мэдээ, нэвтрүүлгийг бүрэн дүүрэн ойлгуулж чаддаг байна. Сонсголгүй иргэдэд зориулан хадмал орчуулга бүхий кино нь дүрүүдийн яриа болон дуу, шум зэргийг текст хэлбэрээр гаргаж үйл явдал, өрнөлийг бүрэн гүйцэд илэрхийлэхийг зорьдог. Хаалга онгойх, буун дуу гэх мэт дуу авиаг “Буугаар буудаж байна, хаалга онгойн чахрах дуу гарч байна” гэхчлэн тайлбарладаг нь эрүүл хүмүүстэй адил тухайн киног бүрэн дүүрэн ойлгох боломж олгодог.

ШИГТГЭЭ

“Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбоо” ТББ-ын үүсгэн байгуулагч Л.Соёлмаа “Чихний эрүүл ахуй болоод сонсголгүй иргэдийн тухай ярьж байгаа хэр нь дохионы орчуулагчгүйгээр цацагдсан нэвтрүүлэг сонсголын бэрхшээлтэй иргэдийг доромжилж байгаагаас өөрцгүй. Энэ нь, хөлгүй хүнд гутал өгч байгаагаас ялгаагүй шүү дээ” хэмээж байв.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” 2013.12.2-ны өдрийн нийтлэл, <http://www.assa.mn/content/18840.shtml> сүүлд үзсэн 2018.6.22-ны өдөр.

Дүгнэлт, Зөвлөмж. ОНРТ хөтөлбөр бэлтгэж түгээхдээ баримтлах бодлогод ХБИ хүртээлтэй, эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөр боловсруулж ажиллаж байх тухай тодорхой заалт байхгүй байна. Тиймээс ОНРТ нь ХБХ мэдээлэл авах эрхийг хангах, нийгмийн оролцоог тэгш хангах, ялгаварлан гадуурхалтыг бий болгохгүйн тулд аливаа хөтөлбөр, кино, нэвтрүүлгийг тэдэнд зориулан хадмал хэлбэрээр, хэлмэрч орчуулагчтай хийж байх тухай зохицуулалт шаардлагатай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Зөрчлийн тухай хууль бусад хууль тогтоомжоор ХБХ эдлэх эрхийг хөндсөн, аливаа зохицуулалт бий эсэхэд үнэлгээ хийж хүмүүсийг үзэл бодол, хөрөнгө чинээ, анги, бүлэг бие эрхтэн, хэл угсаагаар ялгаварлан гадуурхсан, эрхийг нь хязгаарласан, аливаа үйлдлийг хуулиар таслан зогсоож хориглох нь ардчилсан нийгмийн үнэт зүйлийн нэг билээ. Төрөөс хүнийг ХБ-ээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ХБХ нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байна.

Дүгнэлт

Үнэлгээний ажилд сонгосон салбаруудын хүрээнд холбогдох хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийг дараах байдлаар дүгнэв. Үүнд:

1. Хууль зүйн салбар. ХБХ Шударга шүүхээр шүүлгэх, оролцох эрхийг хангасан хэдий ч ХБХЭТ хуулиар заасан ХБХ эрхийг ойлгомжтой тайлбарлаж өгөх, эрхээ хамгаалахад нь хүртээмжтэй орчинг бүрдүүлэх, текст уншигч, бичигч, дохионы хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ажил хийгдээгүй байна. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн зохицуулалтаар “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэмт хэрэгт холбогдсон бол “төлбөрийн чадваргүй яллагдагч” байх тухай тодорхойлсон нь хэл зүй, найруулгын хувьд алдаатай, ойлгомжгүй байдлаар томьёолсон нь хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй зохицуулалт болжээ.

2. Боловсролын салбар. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч эшлэл авсан заалтыг өөрчлөгдөөгүй байгаа, Бага, дунд боловсролын тухай хуулийн “ХБ хүүхдийн насны зөрүүг тодорхойлж сурч боловсрох эрхэд ялгаварлан гадуурхалтыг бий болгох тухай заасан. Халамжийн цэцэрлэгийн тухай заалтыг СӨБ тухай хуульд суулгаж өгсөн хэдий ч хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгаа төдийгүй тусгай цэцэрлэг, сувиллын цэцэрлэг, асрамжийн цэцэрлэг, халамжийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ, хувийн цэцэрлэгүүд яслийн насны хүүхэд болон ХБ хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг боловч тэдний оюуны хөгжилд анхаардаггүй байна.

3. Хөдөлмөрийн салбар. Хөдөлмөрийн тухай хуулиар аж ахуйн нэгж байгууллагад квот тогтоож ажиллуулсан тохиолдолд урамшуулах, ажиллуулаагүй тохиолдолд төлбөр ногдуулах гэсэн хөшүүргийг хэрэглэж байгаа нь ХБИ ажилтай болгох сайн талтай хэдий ч амьдралд хэрэгждэггүй төлбөр төлөгдсөнөөр асуудал

шийдэгдэх нь элбэг тул тогтвортой ажиллах, амьжиргааг дээшлүүлэх, нийгэмшүүлэх боломж болж чадахгүй байгаа юм. Квот тогтоох, төлбөр хураамж ногдуулахаас илүүтэй мэдлэгтэй, боловсролтой, чадвартай ХБХ-ийг сургах, нийгэмшүүлэх, тохирох ажлын байрыг бэлдэх, орчин нөхцөлийг саадгүй болгох хэрэгцээ шаардлага тулгараад байна.

4. Дэд бүтцийн салбар. ХБХ зорчиход шинээр ашиглалтад орсон хэсэг шаардлага хангаж байгаа хэдий ч нэгэнт баригдсан зам, барилгын саадыг хэрхэн сайжруулах тухай зохицуулалт тусгагдаагүй, нийтийн тээврийн 10 хувиар ХБХ зорчих тухай заалт амьдралд нийцэхгүй, хэрэгжилтэд төлбөр ногдуулах төдий асуудлыг шийдэж байгаа нь тэдний эрхийг зөрчин ялгаварлан гадуурхалтад өртөхөд хүргэж байна.

5. Нийгмийн даатгал, халамж, хамгааллын салбар. Халамж, асаргаа шаардлагатай ахмад настан, ХБХ, хүүхэд зэрэгт үзүүлэх үйлчилгээг тэдгээрийн онцлог шаардлагад тулгуурлан хөгжүүлэх, ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын талаар зохицуулсан хууль болон үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүссэн харилцаанд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаар зохицуулсныг холилдуулан утгыг алдагдуулснаас үүдэн иргэдийн эрхийг зөрчих, нийтээр ялгаварлан гадуурхалтад өртөх нөхцөлийг бүрдүүлэхэд хүргээд байна.

6. Бусад салбар. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг бүхэл амьдралын туршид нэг удаа оруулж ирэх нь учир дутагдалтай байна.

Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ баримтлах бодлогод ХБХ хүртээлтэй, эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөр боловсруулж ажиллаж байх тухай тусгасан хэдий ч хэрхэн хангаж ажиллах тухай тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна.

Олон улсын туршлагаас судалж үзвэл ХБ хүний эрхийн зөрчлийг бүрэн дүүрэн тусгасан Конгрессийн бүрэн эрхийн хүрээнд боловсруулдаг улс орнуудын Хүний эрхийн тайланг үргэлжлүүлэн сайжруулж дэлхийн 160 гаруй улс орон ХБ хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг соёрхон баталсан. НҮБ Хүний эрхийн тайланг үргэлжлүүлэн сайжруулах томоохон улсаас төлөөлөн АНУ, ОХУ, ХБНГУ тухай авч үзсэн.

1990 онд Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хууль батлагдсан бөгөөд АНУ-ын 52 сая гаруй ХБИ-ийн хувьд энэ хууль нь Эрх чөлөөний тунхаг гэж үздэг байна. ОХУ-ын тухайд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль” 1995 онд батлагдсан бөгөөд ОХУ-д ХБИ-ийн нийгмийн хамгааллын салбарт төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, ОХУ-ын Үндсэн хуульд заасан иргэний, эдийн засаг, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд ХБ хүнийг адил тэгш боломжоор хангах зорилготой байна. ХБНГУ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль (BGG) 2002 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд ХБ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, тэдний нийгмийн амьдралд тэгш оролцох, өөрсдийгөө тодорхойлдог амьдралын хэв маягийг бий болгоход нь туслахын зэрэгцээ тэдний онцгой хэрэгцээг төрөөс харгалзан үзэхэд оршиж байна.

Зөвлөмж

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж Монгол Улсын Үндсэн хуулиар заасан эрхийг өргөжүүлэн

хуульчилсан. Гэвч хүлээлгэх хариуцлага нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл хориглосон, үүрэгжүүлсэн зохицуулалтад Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцох,

- хууль тогтоомжид “тахир дутуу” гэж зохицуулсан зохицуулалтыг хөгжлийн бэрхшээлтэй гэдэг утгаар өөрчлөх,

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйл, Эрүүл ахуйн тухай хуулийн 2 дугаар зүйл, 5 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйл гэх мэт хууль тогтоомжид заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн нэрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль гэж өөрчлөх,

- Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3.1 дэх заалт” гэж эшлэсэн заалт зөрүүтэй байх тул өөрчлөн найруулах,

- Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д” гэж эшлэсэн заалт зөрүүтэй байх тул өөрчлөн найруулах,

- Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх” тухай заасан байх тул БСШУЯ-аас хэрэгжилтийг хангахад анхаарах нь зүйтэй байна.

- Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэмт хэрэгт холбогдсон нь “төлбөрийн чадваргүй яллагдагч” байх тухай заасан нь хэл зүй, найруулгын хувьд алдаатай, ойлгомжгүй байдлаар томъёолсон төдийгүй гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, хохирогч, болон бусад этгээд, иргэний болон захиргааны хэргийн тухайд төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхгүй байх тул “яллагдагч”-гэдгийг “хүнд” гэж өөрчлөн найруулах,

- шинээр ашиглалтад орсон зорчих замын хэсэг, барилга байгууламж нь шаардлага хангаж байгаа боловч ХБХ бусад иргэдтэй нэгэн адил эрхээ эдлэх, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад хуучин зорчих замын хэсэг, нэгэнт баригдсан барилгын шат болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүнд саад болж буй хэсэг хүндрэлтэй хэвээр байгаа тул хуулийг хэрэгжүүлэхэд тусгайлан анхаарал хандуулан тавигдах стандарт шаардлагад тусгах нь зүйтэй байна.

- Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “... нийтийн тээврийн 10-аас доошгүй хувь нь ХБИ тээвэрлэхэд зориулсан байх” тухай заасан нь тэдний зорчих эрх хангагддаггүй, ялгаварлан гадуурхалтад өртөж байх тул “нийтийн тээврийн хэрэгсэлийг ХБХ тээвэрлэхэд зориулагдсан байх” гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчилалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.” гэж зааснаас үзвэл “ялгаварлан гадуурхах” гэдэг үг нь оновчгүй бөгөөд “алагчилах” гэдэг үгийн утгаар хэрэглэх нь зүйтэй байна.

- Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйл, 46 дугаар зүйл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйл, Гаалийн тухай хуулийн 282 дугаар зүйл, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйл, 12 дугаар зүйл, 20 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйл гэх мэт хууль тогтоомжид “дараахь” гэдэг үг “ь” тэмдэг үсэгтэй бичигдсэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.4 дүгээр зүйлд, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйл гэх мэт хууль тогтоомжид “талаархи” гэж “и” үсэгтэй бичигдсэн байх тул 2018 оны “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-д “дараах” болон “талаарх” гэж бичих тухай журамласныг дагаж мөрдөх нь зүйтэй юм.

ТАВ. НОМ ЗҮЙ

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017 он.
2. Лорд Дюпонт. Хүний эрхийн төлөө: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл Нээлттэй нийгэм форум. “Хүний эрхийн боловсрол” цуврал №6, УБ., 2009 он.
3. Монголын хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхийн цуврал нийтлэл эмхтгэсэн Ц.Адъяахишиг. УБ., 2012 он.
4. Нээлттэй нийгэм форумын бодлогын судлаач Л.Золбаатар “Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх”. УБ., 2006 он.
5. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхтгэл. УБ., 2016 он.
6. УИХ-ын Тамгын газар. Судалгааны эмхтгэл XVII боть. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх болон тэдэнд боловсрол олгох тогтолцооны талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт. /Унгар, Швед, АНУ/, УБ., 2015 он.

Цахим эх сурвалж.

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх эрх зүйн акт. <http://legalinfo.mn/>
2. 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээ, БСШУЯ., <https://mecss.gov.mn/news/718/>
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2018 оны анхны хуралдаан. <http://hudulmur-halamj.gov.mn/news/show/id/753>
4. Б.Дэлгэржаграл. СЗСҮТ., “Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй зарим асуудлуудыг судлах” УБ., 2017 он. https://nrc.gov.mn/disability_studies/
5. Ethical Code for Mongolian Judges 2014,.
6. Хатагтай Трүдо 2016 онд хэлсэн үг. <https://mn.usembassy.gov/mn/remarks-honor-26th-anniversary-americans-disabilities-act-mn/>
7. The Americans with Disabilities Act (ADA) was signed into law on July 26, 1990, https://www.ada.gov/ada_intro.htm
8. Хатагтай Трүдо 2016 онд хэлсэн үг. <https://mn.usembassy.gov/mn/remarks-honor-26th-anniversary-americans-disabilities-act-mn/>
9. Title VII of the Civil Rights Act of 1964: Equal Employment Opportunity, findlaw.com/employment-discrimination/title-vii-of-the-civil-rights-act-of-1964-equal-employment.html The Rehabilitation Act of 1973, <https://www2.ed.gov/policy/special-ed/reg/narrative.html>

10. The Office of Disability Employment Policy (ODEP) under the US Department, <https://www.nypl.org/blog/2015/06/24/employment-services-disabilities>

11. The individuals with Disabilities Education Act (IDEA) <http://www.apa.org/advocacy/education/idea/index.aspx>

12. “О социальной защите инвалидов в Российской Федерации”. <http://docs.cntd.ru/document/901713539> со. ст. 20-2.4.

13. “Трудовой кодекс”. <http://docs.cntd.ru/document/901807664/> со. ст. 92, 94, 96, 99, 113, 128, 224, 261.

14. Об Образований. <http://www.consultant.ru/search/base/?q=об+образова> ний со.ст. 36, 41, 59, 65, 66, 71, 79, 80, 95.

15. Gesetz zur Gleichstellung von Menschen mit Behinderungen (Behindertengleichstellungsgesetz - BGG) <https://www.gesetze-im-internet.de/bgg/> BJNR146800002.html

16. Schwerbehindertengesetz (SchwbG), Gesetz zur Sicherung der Eingliederung Schwerbehinderter in Arbeit, Beruf und Gesellschaft <https://behinderung.org/gesetze/schwbg.htm>

17. Beschäftigung von Schwerbehinderten Menschen. Stand: Januar 2017. kas-sel.de/solva_docs/BeschaeftigungSchwerbehinderte.pdf

18. Grundgesetz für die Bundesrepublik Deutschland <https://www.gesetze-im-internet.de/gg/GG.pdf>

19. Berufsbildungsgesetz (BBiG) <https://www.gesetze-im-internet.de/bbig2005/BbiG.pdf>

ХҮСНЭГТЭН ДАХЬ ИШЛЭЛ

1 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээ, БСШУЯ <https://mecss.gov.mn/news/718/> сүүлд үзсэн 2018.06.19

---o0o---